

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ
УЛСЫН ЭКСПОРТ-ИМПОРТ БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хуулийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн эсэх, газрын тосны хангамж, олборлолт, эх үүсвэр хангалттай эсэх талаар, усны хангамж, нөөцийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Г.Тэмүүлэн нар төсөв хэлэлцэх үед уг хэлэлцээрийг оруулж ирэх боломж байсан эсэх, ямар учраас төсөвт суулгаагүй талаар, нэмэлт санхүүжилттэй холбоотойгоор үндсэн зээлийн эргэн төлөлтийн талаар, хэрэгжих өөр том төсөл байгаа эсэх тухай, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр гүйцэтгэлийн аудит байхгүй байгаа тухай, хэлэлцээрийн санхүүжилттэй холбоотой төсөвт санхүүгийн дарамт үүсэх эсэх, төсөл хэрэгжсэнээр санхүүжилтээ нөхөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан техник, эдийн засгийн үндэслэлийн өртөг нэмэгдэх талаар, төсөл хэрэгжсэн хугацаанд бүтээн байгуулалтын ямар ажил хийгдсэн тухай, шимтгэлд эргэн төлөлт хийгдэж байгаа эсэх, 13,1 сая ам.доллар төлсөн эсэх, эргэн төлөлтийн нөхцөлд хүүгийн тооцоолол байхгүй байгаа талаар, жилд хүүгийн төлбөрд ямар хэмжээтэй төлбөр төлдөг, дефолт хүүгийн талаар гэрээнд тусгагдсан эсэх талаар тодруулан асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар дэмжих шаардлагатай төсөл боловч үйл явц алдаатай, төслийн талаарх мэдээлэл хангалтгүй, эргэлзээтэй нөхцөл байдал үүсгэхгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хангалтгүй, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ байхгүй, газрын тосны хангамж, график, төлөвлөгөөг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төсөлд улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс ямар ч санхүүжилт хийхгүй байхад анхаарах, зээл дахин авахгүй байх, хэлэлцээрт заасан хугацаанд ашиглалтанд оруулах, явцыг тухай бүр дүгнэх, мэдээлэх, худалдан авалт нээлттэй байх, үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг судлах талаар ажиллах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар төсөл улс орны хөгжилд хэрэгтэй эсэх талаар дүгнэх хэрэгтэй талаар, төслийг хэрэгжүүлэхдээ хариуцлагатай хандах, баримт, тооцоотой байхад анхаарах талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжин соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, ~~болов~~ Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг